



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 706

Улаанбаатар хот

┌ Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний
тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн “Замын-Үүдийн дулааны станц” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 он, 2024 оны эхний хагас жилийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 164,176,586.00 (нэг зуун жаран дөрвөн сая нэг зуун далан зургаан мянга таван зуун наян зургаа) төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.“Замын-Үүдийн дулааны станц” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 он, 2024 оны эхний хагас жилийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Замын-Үүдийн дулааны станц” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал (О.Төмөрхуяг)-д Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

3.“Замын-Үүдийн дулааны станц” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал (О.Төмөрхуяг)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

3.1.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

3.2.Үйлдвэрийн газрын санхүү, мөнгөн хөрөнгөд тавих хяналтыг сайжруулж, үргүй зардал гаргахыг таслан зогсоох:

3.2.1.Үйлдвэрийн газрын сахилгын шийтгэлтэй 2 ажилтны цалингаас дутуу суутгасан 435,680.00 (дөрвөн зуун гучин таван мянга зургаан зуун наян) төгрөгийн төлбөрийг нөхөн төлүүлэх;

3.2.2.Аж ахуй нэгжийн орлогын албан татварт илүү шилжүүлсэн 9,938,206.00 (есөн сая есөн зуун гучин найман мянга хоёр зуун зургаа) төгрөгийг залруулга хийлгэж үргүй зардлыг бууруулах;

3.3.Станцын К-3 дугаар зуухны материал буцаагч тоног төхөөрөмжийг “Блэк поржер” ХХК-аас нийлүүлээгүй байхад гэрээ дүгнэж акт үйлдсэн холбогдох албан тушаалтанд хариуцлагын арга хэмжээ тооцох;

3.4.Замын-Үүдийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй, “Замын-Үүдийн дулааны станц”-ын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа ундны усны

эх үүсвэр-1, усны эх үүсвэр-2, бохир ус шахах станц бүхий барилга байгууламжийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авах талаар Дорноговь аймгийн Нутгийн өөрөө удирдах байгууллага, Орон нутгийн өмчийн газарт санал хүргүүлэн шийдвэрлүүлэх;

3.5.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны А-1/2099 дүгээр албан бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах, 2022 он, 2023 оны жилийн эцсийн тооллогоор дутагдсан, 25 нэр төрлийн, 1,359,455,002.18 (нэг тэрбум гурван зуун тавин есөн сая дөрвөн зуун тавин таван мянга хоёр төгрөг арван найман мөнгө) сая төгрөгийн балансын үнэтэй хөрөнгийг хууль хяналтын байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3.6.Үйлдвэрийн газрын балансад бүртгэлтэй ашиглалтын шаардлага хангахгүй болсон 3 нэр төрлийн 16,300.000.00 (арван зургаан сая гурван зуун мянга) төгрөгийн балансын үнэ бүхий тээврийн хэрэгслийг худалдан борлуулах, акталж, данснаас хасах талаарх асуудлыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3.7.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43.3-т “Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно” гэж заасныг мөрдөн ажиллах, шууд гэрээгээр хийх худалдан авалтад урьдчилгаа төлбөр олгохгүй байх;

3.8.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 106 дугаар тогтоолын хавсралт

“Замын-Үүдийн дулааны станц” төрийн өмчит үйлдвэрийн газарт хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн (төгрөгөөр)	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Үйлдвэрийн 2 ажилтны цалингаас сахилгын шийтгэлийг дутуу суутгасан	435,680.00	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх заалтыг мөрдөж ажиллах.
2	Илүү шилжүүлсэн аж ахуй нэгжийн орлогын албан татвар	9,938,206.00	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт, “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-ний 3 дугаар зүйлийн 3.2.2 дахь заалтыг мөрдөж ажиллах.
3	Бараа худалдан авах төсөвт өртгөөс хэтрүүлэн авсан худалдан авалт	53,218,720.00	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.3, 36.1.5, 36.1.6 дахь заалтыг мөрдөж ажиллах.
4	Тендер шалгаруулалтын арга буруу сонгосон худалдан авалт	100,583,980	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 зүйлийн 10.3 дахь заалтыг мөрдөж ажиллах
Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн нийт дүн		164,176,586.00	(нэг зуун жаран дөрвөн сая нэг зуун далан зургаан мянга таван зуун наян зургаа) төгрөг